



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 8/18

Хараат

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Замын улаан багийн нутаг “Хөх хошуу” гэдэг газарт өвөлжиж байгаа малчин Д.Мягмардорж суурьт малын гоц халдварт бог малын Мялзан өвчин оношлогдож хорио цээрийн дэглэмийн хугацаанд сүүлчийн мал эдгэрснээс хойш 21 хоногийн хугацаанд нэмэж мал өвчлөөгүй тул 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Хязгаарлалтын бүсэд байгаа малд шинжилгээ, үзлэг тандалт, ариутгал халдвартайжүүлэлтийн ажлыг зохион байгуулахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (Ж.Чулуунбатаа)-д үүрэг болгосугай.

3. Малчид иргэд олон нийтэд малын гоц халдварт бог малын Мялзан өвчинөөс урьдчилан сэргийлэх, гарын авлаг, мэдээ мэдээллийг цахимаар олон нийтэд хүргэх, голомт сэжигтэй бүс нутгийн малчдад малын хариуллага маллагаатай байлгаж, хязгаарлалтын дэглэмийн журмыг мөрдөж ажиллах талаар мэдээл өгөхийг МЭТасгийн дарга (Т.Өлзийбат), БЗДарга нарт үүрэг болгосугай.

4. Дээрх үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн зардлын тооцоог гаргахыг ЗДТГазрын санхүү албаны дарга (Б.Цэндмаа), нягтлан бодогч (Ж.Чулуунтогтох) нарт даалгасугай.



ЗАСАГ ДАРГА А. ЭРДЭНЭСАЙХАН

4823000064